



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2018/01/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор Б.Ариунжаргал

Утас: 260512 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	ХУРААНГУЙ ТАЙЛАН	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	6
3	АУДИТЫН ТАЙЛАН	8
3.1	Оршил	8
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	8
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	9
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
3.5	Дотоод аудит	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
3.7	Шилэн дансны мэдээлэл	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	11
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	11
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	14
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	14
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	15
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3.16	Үр өгөөжийн тооцоолол	15
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	16
4.1	Үндсэн хөрөнгийн талаар	17
4.2	Зардлын талаар	18
4.3	Дотоод аудитын талаар	22
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	23
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	23
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	24
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	25
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
6	АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	29

1 АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2018/01/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Санхүүгийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Л.Хонгорзул Аудитор Б.Ариунжаргал
Аудитын нэр:	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Ерөнхийлөгчийн Тамгын газар /ТЕЗ/	1	1				1			
1.1	Ерөнхийлөгчийн төсөв	1		1						
1.2	Ерөнхийлөгчийн Тамгын газар	1		1						
1.3	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба	1		1						
1.4	Иргэдийн оролцоо төсөл	1				1				
	ДҮН	5	1	3		1	1			

Гурав. Аудитын үр дүн

3.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс						Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Ерөнхийлөгчийн төсөв	4	539.3	6	539.3					
2	Ерөнхийлөгчийн Тамгын газар	4	96.6	5	96.6					
3	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба	2	108.1	2	108.1					
	ДҮН	10	744.0	13	744.0					

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулбал:

Ерөнхийлөгчийн төсөв

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Гадаад, дотоодын зочны гарын бэлэг, дурсгалын зардалд 2017 онд нийт 87.9 сая төгрөг зарцуулснаас 1 хүнд 0.2-10.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгөхөд нийт 66.8 сая төгрөг зарцуулсан, гадаад айлчлалын бэлэг дурсгалаас бусад арга хэмжээнд төсөв батлуулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргаж санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 3.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ын 2.3-т “Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянган төгрөг ... илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор тооцож төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж өгнө”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын “томилолт, зочны зардал” ангилалд “...тусгайлсан удирдамж, програмаар гадаад, дотоодод албан томилолтоор ажиллахтай холбогдсон бэлэг дурсгал...” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг баримталж, журамд зааснаас илүү үнийн дүнтэй бэлэг дурсгал олгохгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Тайлант онд урсгал зардлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй нийт 36.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөл авч байх зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Цагаан сарын баярыг тохиолдуулан 100-аас дээш насны ахмад настанд Ерөнхийлөгчийн гарын бэлэг олгохоор Тамгын газрын дэд даргын тушаал гаргаж нийт 450 хүнд, 1 хүнд 170.1 мянган төгрөгийн бэлэг ногдохоор тооцож 76.5 сая төгрөг зарцуулснаас 120 ширхэг нь хэнд олгосон нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, гадаад томилолтын арга хэмжээнд зарцуулсан 4.8 сая төгрөгийн холбогдох анхан шатны баримтыг хавсаргаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнд 104.5 сая, төрийн одон медаль хийлгэхтэй холбоотой зардалд 285.8 сая, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутагт хийх 3 удаагийн уулзалт арга хэмжээнд оролцсон сэтгүүлчдийн томилолтын зардалд 20.8 сая төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Ерөнхийлөгчийн Тамгын газар

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Тайлант онд урсгал зардлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй нийт 23.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулал-тын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Тайлант онд улс төрийн албан тушаалтан 9, төрийн захиргааны 14 ажилтныг ажлаас чөлөөлж нийт 53.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 40, 42 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж, ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 35-40 хувиар тогтоож, 1.8 сая төгрөгийн илүү зардал гаргасан нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн

сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийн хэмжээг холбогдох журамд нийцүүлэн тогтоох зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Ерөнхийлөгчийн Тамгын газрын 6 ажилтны дипломын болон докторын сургалтын төлбөрт 15.5 сая, 1 ажилтны хүүхдэд гадаадад сурах сургалтын төлбөрт 2.8 сая төгрөгийн дэмжлэгийг төсвөөс төлж, зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, УИХ, ЗГ-аас төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэрүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж, ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Ерөнхийлөгчийн Тамгын газарт мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Нэмэлт санхүүжилтийн он дамжин зарцуулагдах 43.1 сая төгрөгийн үлдэгдлийг Сангийн яаманд татан төвлөрүүлж, буцаан олгохоор тооцоо нийлснийг авлагаар бүртгээгүй, зардлаар хүлээн зөвшөөрч, тайлант оны санхүүгийн үр дүнг бууруулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах зөвлөмж өгч, залруулга хийлгэсэн.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

“Монгол хэлний үсгийн дүрмийн журамласан толь”-ийн цахим хувилбар, гар утасны аппликэйшн бэлтгэх, сурталчилгаа, нэвтрүүлэг бэлтгэх зэрэг нийт 65.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг нэр бүхий 5 компанитай байгуулж, тайлант онд гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй, төлбөрийг бүрэн шилжүүлсэн нь Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-д “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх”, 351 дүгээр зүйлийн 351.2-т “гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах” болон гэрээний холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгүүлэх гэрээний захиалагчийн эрх үүргийн дагуу гүйцэтгүүлсэн ажлуудыг хүлээн авах зөвлөмж хүргүүлэх.

3.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,985.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 99.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон. Аудитаар илэрсэн залруулагдаагүй материаллаг алдаа, зөрчлийн нийт дүн 92.0 сая төгрөг байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байгаа тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА З.ЭНХБОЛД
ТАНАА

2018.04.25 № 1016
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга 3.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгө бэлтгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 18-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Ариунжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн ТГ/283 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрэм”-ийг баталсан байна. Тус дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1-д *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий төрийн байгууллага мөн”* гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулж, Ерөнхийлөгчийг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, алсыг харсан, мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээгээр хангаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийн хөтөч байхад оршино”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тамгын газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг удирдлага болгон ажилладаг.
- Тамгын газар үйл ажиллагаагаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилгыг биелүүлэхэд чиглүүлж, холбогдох байгууллагуудтай нягт уялдуулан явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн”* гэж заасны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” 23 дугаар захирамжаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг баталсны дагуу тайлант оны эцэст улс төрийн албан тушаалтан-30, төрийн захиргааны албан хаагч-23, төрийн үйлчилгээний албан хаагч-2, нийт 55 хүн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 23 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашигласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын эрсдэлийг “их” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж буй ажилтны үйл ажиллагаатай танилцаж, үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан ёсоор ажлын байрны тодорхойлолтод дотоод аудитын чиглэлээр үйл ажиллагаа явуулах үүрэг, чиглэл бүхий албан тушаалтан байхгүй байгаа тул тайлант онд энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй, хийгдсэн ажил байхгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд нийт 4,561.4 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 4,502.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1.3 хувиар буюу 58.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсөв хэмнэсэн гол шалтгаан нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 32.6 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дэлгэрэнгүйд тусгаж тайлангийн 5.5-д харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд *shilendans.gov.mn* цахим хуудасны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цонхнуудад дараах мэдээллийг байршуулж байх үүрэгтэй байна. Үүнд:

А. Төсөв/гүйцэтгэл цэсэнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр);
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр);
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр).

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаар шалгаж үзэхэд бүх мэдээллийг бүрэн байршуулж хэвшсэн байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 23 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

1. Ерөнхийлөгчийн төсвийн зарцуулалттай холбоотой 539.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд урсгал зардлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй нийт 36.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөл авч байх зөвлөмж хүргүүлэх.

- Гадаад, дотоодын зочны гарын бэлэг, дурсгалын зардалд 2017 онд нийт 87.9 сая төгрөг зарцуулснаас 1 хүнд 0.2-10.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгөхөд нийт 66.8 сая төгрөг зарцуулсан, гадаад айлчлалын бэлэг дурсгалаас бусад арга хэмжээнд төсөв батлуулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргаж санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 3.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ын 2.3-т "Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянган төгрөг ... илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор тооцож төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж өгнө", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын "томилолт, зочны зардал" ангилалд "...тусгайлсан удирдамж, програмаар гадаад, дотоодод албан томилолтоор ажиллахтай холбогдсон бэлэг дурсгал..." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ыг баримталж, журамд зааснаас илүү үнийн дүнтэй бэлэг дурсгал олгохгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

- Цагаан сарын баярыг тохиолдуулан 100-аас дээш насны ахмад настанд Ерөнхийлөгчийн гарын бэлэг олгохоор Тамгын газрын дэд даргын тушаал гаргаж, нийт 450 хүнд, 1 хүнд 170.1 мянган төгрөгийн бэлэг ногдохоор тооцож 76.5 сая төгрөг зарцуулснаас 120 ширхэг бэлэг нь хэнд олгосон нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, гадаад томилолтын арга хэмжээнд зарцуулсан 4.8 сая төгрөгийн холбогдох анхан шатны баримтыг хавсаргаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнд 104.5 сая, төрийн одон медаль хийлгэхтэй холбоотой зардалд 285.8 сая, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутагт хийх 3 удаагийн уулзалт арга хэмжээнд оролцсон сэтгүүлчдийн томилолтын зардалд 20.8 сая төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

2. Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсвийн зарцуулалттай холбоотой 96.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд урсгал зардлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй нийт 23.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

- Тайлант онд улс төрийн албан тушаалтан 9, төрийн захиргааны 14 ажилтныг ажлаас чөлөөлж нийт 53.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 40, 42 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

- Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 35-40 хувиар тогтоож, 1.8 сая төгрөгийн илүү зардал гаргасан нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийн хэмжээг холбогдох журамд нийцүүлэн тогтоох зөвлөмж хүргүүлэх.

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын 6 ажилтны дипломын болон докторын сургалтын төлбөрт 15.5 сая, 1 ажилтны хүүхдэд гадаадад сурах сургалтын төлбөрт 2.8 сая төгрөгийн дэмжлэгийг төсвөөс төлж, зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, УИХ, Засгийн газраас төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар гаргасан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

- Ерөнхийлөгчийн Тамгын газарт мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 108.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн он дамжин зарцуулагдах 43.1 сая төгрөгийн үлдэгдлийг Сангийн яаманд татан төвлөрүүлж, буцаан олгохоор тооцоо нийлснийг авлагаар бүртгээгүй, зардлаар хүлээн зөвшөөрч, тайлант оны санхүүгийн үр дүнг бууруулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

- "Монгол хэлний үсгийн дүрмийн журамласан толь"-ийн цахим хувилбар болон гар утасны аппликейшн танилцуулга, 2D анимэйшн бэлтгэх, IOS, Андроид үйлдлийн системд тохирсон гар утасны аппликейшн хийх зэрэг нийт 28.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг нэр бүхий 2 компанитай байгуулж, тайлант онд гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй, төлбөрийг бүрэн шилжүүлсэн нь Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", 351 дүгээр зүйлийн 351.2-т "гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах" болон гэрээний холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгүүлэх гэрээнд заасан захиалагчийн эрх үүргийн дагуу гүйцэтгүүлсэн ажлуудыг хүлээн авах зөвлөмж хүргүүлэх.

- "Монгол хэлний үсгийн дүрмийн журамласан толь"-ийн сурталчилгаа, нэвтрүүлэг бэлтгэх, ярилцлага, мэдээ, тодруулгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх зэрэг 37.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг 3 компанитай байгуулж, тайлант онд гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй, төлбөрийг бүрэн шилжүүлсэн нь Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", 351 дүгээр зүйлийн 351.2-т "гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах" болон гэрээний холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгүүлэх гэрээний захиалагчийн эрх үүргийн дагуу гүйцэтгүүлсэн ажлуудыг хүлээн авах зөвлөмж хүргүүлэх.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцад нэгтгэгддэг нийт 903.2 сая төгрөгийн эх үүсвэр бүхий Швейцарийн хөгжлийн сангийн санхүүжилттэй Иргэдийн оролцоо төсөл нь 2015 оны 09 дүгээр сараас хэрэгжиж эхлээд 2017 оны 04 дүгээр сард хугацаа дуусч хаагдсан байна.

Дээрх төслийн 2017 оны төсөл хаагдах хүртэл хугацааны санхүүгийн тайланд "BDO" аудит ХХК аудит хийж, дүгнэлт гаргасан бөгөөд тус төсөл нь хаалтын тайлан гаргаагүй, үлдэгдлийг Сангийн яам шууд татаж, үлдэгдэлгүй болсон гэсэн тайлбарыг өгсөн болно.

Энэ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, аудитын зарим чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ, аудит хийж буй цаг хугацааны хязгаарлагдмал байдал зэргээс үзэхэд 2018 оны завсрын аудитаар дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн зардлын төлөвлөлтийн үндэслэл, гүйцэтгэл;
- Томилолт, зочны зардлын төлөвлөлтийн үндэслэл, гүйцэтгэл.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд хамрагдсан харьяа 4 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 744.0 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Аудитаар илэрсэн дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар 9 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн ТГ/982 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,985.2 сая төгрөг, түүний 2 хувь 99.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 169.5 сая төгрөгийн аудитын үр өгөөжийн тооцооллыг /Маягт УАГ 1120/ хийв.

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон бусад холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

4.1 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд урсгал зардлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй нийт 59.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөл авч байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

- Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах;
- Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

4.2 Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт 1:

Гадаад, дотоодын зочны гарын бэлэг, дурсгалын зардалд 2017 онд нийт 87.9 сая төгрөг зарцуулснаас 1 хүнд 0.2-10.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгөхөд нийт 66.8 сая төгрөг зарцуулсан, гадаад айлчлалын бэлэг дурсгалаас бусад арга хэмжээнд төсөв батлуулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргаж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 3.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ын 2.3-т "Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянган төгрөг ... илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор тооцож төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж өгнө", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын "томилолт, зочны зардал" ангилалд "...тусгайлсан удирдамж, програмаар гадаад, дотоодод албан томилолтоор ажиллахтай холбогдсон бэлэг дурсгал..." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

- Хууль тогтоомжийн хэрэжилт хангалтгүй байх;
- Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд: **Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

ҮАГ-ын зөвлөмж 1:

Батлагдсан төсвийн хүрээнд хууль, журмаар тогтоосноос илүү үнийн дүнтэй бэлэг дурсгал олгохгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын ажиглалт 2:

Цагаан сарын баярыг тохиолдуулан 100-аас дээш насны ахмад настанд Ерөнхийлөгчийн гарын бэлэг олгохоор Тамгын газрын дэд даргын тушаал гаргаж нийт 450 хүнд, 1 хүнд 170.1 мянган төгрөгийн бэлэг ногдохоор тооцож 76.5 сая төгрөг зарцуулснаас 120 ширхэг нь бэлэг нь хэнд олгосон нь тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, гадаад томилолтын арга хэмжээнд зарцуулсан 4.8 сая төгрөгийн холбогдох анхан шатны баримтыг хавсаргаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Хууль тогтоомж зөрчигдөх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

ҮАГ-ын ажиглалт 3:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнд 104.5 сая, төрийн одон медаль хийлгэхтэй холбоотой зардалд 285.8 сая, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутагт хийх 3 удаагийн уулзалт арга хэмжээнд оролцсон сэтгүүлчдийн томилолтын зардалд 20.8 сая төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

ҮАГ-ын зөвлөмж 2:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж 3:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын ажиглалт 4:

Тайлант онд улс төрийн албан тушаалтан 9, төрийн захиргааны 14 ажилтныг ажлаас чөлөөлж нийт 53.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 40, 42 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж зөрчигдөх

ҮАГ-ын ажиглалт 5:

Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 35-40 хувиар тогтоож, 1.8 сая төгрөгийн илүү зардал гаргасан нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Хууль тогтоомж зөрчигдөх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах.

ҮАГ-ын зөвлөмж 4:

Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж 5:

Төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийн хэмжээг холбогдох журамд нийцүүлэн тогтоох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын ажиглалт 6:

Ерөнхийлөгчийн Тамгын газрын 6 ажилтны дипломын болон докторын сургалтын төлбөрт 15.5 сая, 1 ажилтны хүүхдэд гадаадад сурах сургалтын төлбөрт 2.8 сая төгрөгийн дэмжлэгийг төсвөөс төлж, зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, УИХ, Засгийн газраас төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар гаргасан тогтоол, шийдвэрүүдтэй нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

ҮАГ-ын ажиглалт 7:

"Монгол хэлний үсгийн дүрмийн журамласан толь"-ийн цахим хувилбар, гар утасны аппликэйшн бэлтгэх, сурталчилгаа, нэвтрүүлэг бэлтгэх зэрэг нийт 65.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг нэр бүхий 5 компанитай байгуулж, тайлант онд гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй, төлбөрийг 100 хувь шилжүүлсэн нь Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", 351 дүгээр зүйлийн 351.2-т "гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах" болон гэрээний холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

ҮАГ-ын зөвлөмж 6:

Тушаал шийдвэр гаргахдаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж 7:

Ажил гүйцэтгүүлэх гэрээний захиалагчийн эрх үүргийн дагуу гүйцэтгүүлсэн ажлуудыг хүлээн авах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

4.3 Дотоод аудитын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Ерөнхийлөгчийн Тамгын газарт мониторинг, дотоод хяналт хариуцсан ахлах референт ажиллаж байгаа боловч ажлын байрны тодорхойлолтод хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагад дэмжлэг үзүүлэх талаар тусгагдаагүй, энэ чиглэлээр ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх.

Төсвийн захирагчийн хариу:

Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	723,775.1	538,967.1
31	Мөнгөн хөрөнгө	127,733.0	622.8
33	Авлага	180,000.4	113,652.4
35	Бараа материал	416,041.7	424,691.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	234,892.2	208,244.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	234,892.2	208,244.6
39200	Биет хөрөнгө	234,892.2	208,244.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	958,667.3	747,211.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,748.1	0.0
41	Богино хугацаат өр төлбөр	11,748.1	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	946,919.2	747,211.8
51	Засгийн газрын хувь оролцоо	946,919.2	747,211.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	419,275.6	419,275.6
51200	Хуримтлагдсан үр дүн	511,120.90	311,413.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,522.7	16,522.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	958,667.3	747,211.8

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	/мян.төг/	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,605,381.50	4,975,794.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	825,303.20	201,983.9
120	Нийтлэг татварын бус орлого	243,278.3	6,762.2
122	Тусламжийн орлого	582,024.8	195,221.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,780,078.3	4,773,810.2
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,816,909.2	5,175,501.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,816,909.2	5,175,501.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,258,869.2	4,801,372.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,148,863.3	1,046,430.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,614.5	116,108.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,680.3	3,635.3
2104	Хангамж, бараа материалын зардал	171,067.5	170,596.5
2105	Нормативт зардал	2,184.8	4,646.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,531.4	18,367.0
2107	Томилолт, зочны зардал	1,145,296.2	1,029,983.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,471.7	238,862.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,297,159.6	2,172,743.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	558,040.0	374,128.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(211,527.8)	(199,707.4)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(211,527.8)	(199,707.4)

5.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
3	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,293.6	0.0	1,277,293.6
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(27,451.6)	0.0	(27,451.6)
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,249,842.0	0.0	1,249,842.0
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(12,128.4)	0.0	(12,128.4)
7	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(79,266.7)	0.0	(79,266.7)
9	Тайлант үеийн үр дүн	(211,527.8)	0.0	(211,527.8)
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	946,919.2	0.0	946,919.2
11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	946,919.2	0.0	946,919.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	946,919.2	0.0	946,919.2
19	Тайлант үеийн үр дүн	(199,707.4)	0.0	(199,707.4)
20	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	747,211.8	0.0	747,211.8

5.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,576,718.1	4,975,794.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	789,076.3	201,983.9
120	Нийтлэг татварын бус орлого	207,051.5	6,762.2
122	Тусламжийн орлого	582,024.8	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,787,641.8	4,773,810.2
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,533,968.4	5,043,313.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,533,968.4	5,043,313.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,975,928.4	4,626,074.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,111,704.8	1,046,733.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,624.1	116,108.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,680.3	3,635.3
2104	Хангамж, бараа материалын зардал	171,348.0	165,905.0
2105	Нормативт зардал	2,184.8	4,646.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,634.2	18,890.4
2107	Томилолт, зочны зардал	1,269,268.4	963,626.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	376,167.7	242,493.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	907,316.1	2,064,035.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	558,040.0	410,339.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	42,749.8	(67,519.4)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.0	59,590.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	59,590.8
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	59,590.8
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	(59,590.8)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	42,749.8	(127,110.2)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,983.2	127,733.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	127,733.0	622.8

4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,561,391,500.00	4,502,441,867.25	(58,949,632.75)	98.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,561,391,500.00	4,502,441,867.25	(58,949,632.75)	98.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,262,803,700.00	4,238,061,769.25	(24,741,930.75)	99.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	989,866,300.00	986,796,016.38	(3,070,283.62)	99.69
210101	Үндсэн цалин	643,884,100.00	640,813,816.38	(3,070,283.62)	99.52
210102	Нэмэгдэл	264,307,200.00	264,307,200.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	81,675,000.00	81,675,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,885,200.00	108,640,867.48	(244,332.52)	99.78
210201	Тэтгэврийн даатгал	69,290,600.00	68,722,881.06	(567,718.94)	99.18
210202	Тэтгэмжийн даатгал	9,898,800.00	9,188,858.69	(709,941.31)	92.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,918,800.00	8,778,375.26	859,575.26	110.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,979,700.00	2,054,039.89	74,339.89	103.76
210205	Эрүүл мэндийн даатгал	19,797,300.00	19,896,712.58	99,412.58	100.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,635,300.00	3,635,300.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	3,635,300.00	3,635,300.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	173,458,900.00	165,348,301.29	(8,110,598.71)	95.32
210401	Бичиг хэрэг	16,949,200.00	17,333,539.00	384,339.00	102.27
210402	Тээвэр, шатахуун	106,995,000.00	106,676,486.00	(318,514.00)	99.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,922,500.00	40,746,076.29	(8,176,423.71)	83.29
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	592,200.00	592,200.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	4,950,000.00	4,646,060.00	(303,940.00)	93.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,950,000.00	4,646,060.00	(303,940.00)	93.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,042,100.00	23,874,213.00	(167,887.00)	99.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,889,400.00	7,487,266.00	(9,402,134.00)	44.33
210604	Урсгал засвар	7,152,700.00	16,386,947.00	9,234,247.00	229.10
2107	Томилолт, зочны зардал	925,968,600.00	913,279,457.55	(12,689,142.45)	98.63
210701	Гадаад албан томилолт	672,742,700.00	666,805,630.58	(5,937,069.42)	99.12
210702	Дотоод албан томилолт	68,206,500.00	61,471,497.00	(6,735,003.00)	90.13
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	185,019,400.00	185,002,329.97	(17,070.03)	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,108,300.00	13,107,670.00	(630.00)	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,108,300.00	13,107,670.00	(630.00)	100.00

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,018,889,000.00	2,018,733,883.55	(155,116.45)	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,959,992,100.00	1,959,854,783.55	(137,316.45)	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,896,900.00	58,879,100.00	(17,800.00)	99.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	298,587,800.00	264,380,098.00	(34,207,702.00)	88.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	298,587,800.00	264,380,098.00	(34,207,702.00)	88.54
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,577,000.00	95,138,217.00	(1,438,783.00)	98.51
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,000,000.00	89,879,359.00	(120,641.00)	99.87
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,310,800.00	64,662,522.00	(32,648,278.00)	66.45
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,700,000.00	14,700,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,561,391,500.00	4,500,727,667.25	(60,663,832.75)	98.67
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,561,391,500.00	4,500,727,667.25	(60,663,832.75)	98.67
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,561,391,500.00	4,500,727,667.25	(60,663,832.75)	98.67
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,325,000.00	2,325,000.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	610,800.00	610,800.00	0.00

6 АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2018.04.20			САГ-2018/01/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар</i>		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгуулл а-гаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Гадаад, дотоодын зочны гарын бэлэг, дурсгалын зардалд 2017 онд нийт 87.9 сая төгрөг зарцуулснаас 1 хүнд 0.2-10.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгөхөд нийт 66.8 сая төгрөг зарцуулсан, гадаад айлчлалын бэлэг дурсгалаас бусад арга хэмжээнд төсөв батлуулдаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлага гаргаж санхүүгийн тайланд тусгасан байна.	66.8	Зөвлөмж	-МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга асан, -МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, -Нягтлан бодогч	-Б.Нэргүй -Г.Байгалмаа -Г.Амгалан
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй 104.5 сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлсэн, төрийн одон медаль хийлгэхтэй холбоотой зардалд 285.8 сая, Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон нутагт хийх 3 удаагийн уулзалт арга хэмжээнд оролцсон сэтгүүлчдийн томилолтын зардалд 20.8 сая төгрөг зарцуулсан.	411.1	Зөвлөмж	-МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга асан, -МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, -Нягтлан бодогч	-Б.Нэргүй -Г.Байгалмаа -Г.Амгалан
3	"Монгол хэлний үсгийн дүрмийн журамласан толь"-ийн цахим хувилбар, гар утасны аппликэйшн бэлтгэх, сурталчилгаа, нэвтрүүлэг бэлтгэх зэрэг нийт 65.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг нэр бүхий 6 компанитай байгуулж, тайлант онд гэрээний хугацаа дууссан боловч ажлыг хүлээж аваагүй, төлбөрийг бүрэн шилжүүлсэн.	65.0	Зөвлөмж	-Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, -Нягтлан бодогч	-Н.Нарангэрэл -Ж.Наранчимэг

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for writing. There are no margins, text, or other markings on the page.

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting or typing. There are no margins, text, or other markings on the page.